

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

Агуулга.....	1
1 Аудитын гэрчилгээ.....	2
2 Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Зорилтот түвшиний биелэлтийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3 Менежментийн захидал.....	11
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	16

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ЭХЗХ	Эрчим хүчний зохицуулах хороо
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЭХЯ	Эрчим хүчний яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛААНБААТАР ЦАХИЛГААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.БАЯРСАЙХАН ТАНАА

2020.03.13 № 06/851
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль, тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай, нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц. Наранчимэг Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Баярсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудлыг шийдэх, авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах, тайлант хугацааны зардлыг аккруэл сууриар бүртгэх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, түүнд нийцүүлэн гаргасан сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 11-нээс 2019 оны 3 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Грант Торнтон аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг “Грант Торнтон аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 30-ний өдрийн 1/216 дугаар албан бичгээр хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль эрх зүйн орчин

Чадварлаг ажилтнуудаар чанартай үйлчилгээг хэрэглэгчдэдээ хүргэж, цахилгаан эрчим хүчийг найдвартай түгээгч, аюулгүй ажиллагааг хангасан, үйлдвэрлэл, үйлчилгээний найдвартай, тогтвортой нөхцөлийг хангах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь Монгол улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог”, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-д “Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ өөрөө бие даан борлуулдаг” гэсэн хуулийн заалтад нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”
- Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”
- Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус компанийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Даймонд-05” програм хангамж ашигладаг байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитын гүйцэтгэлийн үе шатанд 15 эрсдэлтэй асуудал тодорхойлж эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 11 асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийг их гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоосон.

Компани нь өөрийн үйл ажиллагааны үндсэн болон үндсэн бус орлогоор үйл ажиллагааны зардлаа санхүүжүүлдэг тул тайлант жилийн зарцуулалтыг батлагдсан зорилтот түвшний дагуу үнэн зөв зарцуулсан эсэхийг тодорхойлохын тулд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонголоо.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 479,202.5 сая төгрөгөөс 1 хувиар тооцон 4,792.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,320.89 сая төгрөгөөр буюу 101.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, Засгийн газрын оролцоо/ эздийн өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Эргэлтийн хөрөнгийн дүн	41,185.1	47,606.8	6,421.7
Мөнгөн хөрөнгө	1,879.4	2,116.1	236.7
Авлага	30,222.2	35,904.5	5,682.3
Урьдчилж төлсөн зардал тооцоо	167.8	45.6	(122.2)
Бараа материал	8,915.7	9,540.6	624.9
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	236,536.8	232,436.0	(4,100.9)
Үндсэн хөрөнгө	218,005.8	224,257.0	6,251.2
Биет бус хөрөнгө	848.0	737.9	(110.1)
Бусад эргэлтийн бус хөрөнгө	17,683.0	7,441.1	(10,241.9)
Нийт хөрөнгийн дүн	277,721.9	280,042.8	2,320.9
Нийт өр төлбөр	94,926.8	87,461.6	(7,465.3)
Богино хугацаат өр төлбөр	39,562.6	33,909.4	(5,653.1)
Урт хугацаат өр төлбөр	55,364.3	53,552.1	(1,812.1)
Засгийн газрын оролцоо (Эздийн өмч)	80,760.0	118,530.9	37,770.8
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	51,319.4	48,677.8	(2,641.6)
Эздийн өмчийн бусад хэсэг	44,371.1	18,254.9	(26,116.2)
Хуримтлагдсан ашиг	6,344.6	7,117.7	773.1
Нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	277,721.9	280,042.8	2,320.9

Авлага дансны үлдэгдэл 5,682.3 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд цахилгаан эрчим хүчний авлага 5,982.4 сая төгрөг, НӨАТ-ын авлага 131.3 сая төгрөг, Сэргээгдэх эрчим хүчний гүйцэтгэсэн ажлын акт бичигдээгүй тул 377.0 сая төгрөгөөр тус тус өсч, бэлтгэн нийлүүлэгчээс авах авлага 367.0 сая төгрөг, Төлөвлөгөөт их урсгал засварын ажлын авлага 13,235.3 сая төгрөг, Ажилтан албан хаагчдаас авах авлага 41,595.0 сая төгрөг, Байгаль орчны яамнаас авах Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхөд үзүүлэх цахилгааны тарифын утааны хөнгөлөлтийн авлага 338.3 сая төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 624.9 сая төгрөгөөр нэмэгдэж 9,540.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бараа материалын үлдэгдлийн 69.3 хувь буюу 9,077.2 сая төгрөгийг үндсэн сэлбэг хэрэгсэл, 30.6 хувь буюу 4,011.0 сая төгрөгийг аваарын нөөц, хөдөлмөр хамгааллын багаж хэрэгсэл, хангамжийн материал эзэлж байна. Тайлант онд

нийт 25,542.1 сая төгрөгийн худалдан авалт хийж, 24,917.2 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 615 дугаар тогтоолоор Улс болон Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд эрчим хүчний салбарт бий болсон барилга байгууламжийг үнэ төлбөргүй хүлээн авсан 11,701.9 сая төгрөг, өөрөө үйлдвэрлэсэн /их засвар болон хөрөнгө оруулалт/ 9,493.5 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 482 дугаар тогтоолоор “Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-д үнэ төлбөргүй шилжүүлсэн 90.9 сая төгрөг, 2019 оны 49 дугаар тогтоолоор “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-д үнэ төлбөргүй шилжүүлсэн 190.7 сая төгрөг, 2019 оны 501 дугаар тогтоолоор акталсан 731.0 сая төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансанд жилийн үр дүнгийн шагналт цалингийн өглөг 2,701.0 сая төгрөг, ХХОАТ-ын өглөг 5,012.0 сая төгрөг, ААНОАТ-ын өглөг 293,593.2 сая төгрөг, Улсын төсвийн цахилгаан эрчим хүчний урьдчилан төсөлсөн төлбөр 1,201.4 сая төгрөг, хувь хүмүүст өгөх 46,710.1 сая төгрөг, бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх гэрээт ажлын баталгааны өглөг 4,540.0 сая төгрөг, Орон сууц нийтийн аж ахуйн компаниудад өгөх 1,129.2 сая төгрөг, Чингэлтэй дүүргийн хэрэглэгчдэд үйлчлэх төвийн барилга, орон сууцны урьдчилгаа 3,164.0 сая төгрөг, МҮОНРТ-д өгөх телевизийн хураамж 536.0 сая төгрөг, татварын ерөнхий газарт өгөх хогны хураамж 104.0 сая төгрөгийн өглөгийг тус тус бүртгэсэн байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд Азийн хөгжлийн банкны MN-1479 төслийн зээлийн өглөг 55.0 сая төгрөг, Дэлхийн банкны MN-35038 MN-4673 тоот зээлийн 33,170.5 сая төгрөг, санхүү, татварын зөрүүгийн тайлангаар үүссэн 3,076.4 сая төгрөгийн хойшлогдсон татварын өглөгийг тус тус бүртгэсэн байна.

Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 11 тоот тогтоолоор эздийн өмч дэх төрийн өмчийн дүнг нэмэгдүүлэх, дүрэмд өөрчлөлт оруулсан байна. Энэ нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 12 нэр төрлийн нийт 37,904.0 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийн дүнгээр эздийн өмч дэх төрийн өмчийн дүнг нэмэгдүүлсэн байна.

2.9. Зорилтот түвшиний биелэлтийн талаарх тайлбар, тодруулга

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Эрчим хүчний сайдын 2019 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 24 дугаар тушаал, Эрчим хүчний зохицуулах хорооны “тариф батлах тухай” 2019 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 48 дугаар тогтоолоор Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшнийг баталсан байна.

Тайлант онд батлагдсан төлөвлөгөөгөөр 478,605.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 486,842.0 сая төгрөгийн зардал батлагдсан байна.

Цахилгаан эрчим хүчний борлуулалтын орлого 405,624.3 сая, түгээх үйлчилгээний орлого 64,016.7 сая, үндсэн бус үйл ажиллагааны орлогоос 8,964.4 сая төгрөгийн бүрдүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр цахилгаан эрчим хүчний орлого 401,988.3 сая төгрөгт хүрч 1.9 хувиар буюу 3,636.0 сая төгрөгөөр тасарсан, түгээх үйлчилгээний орлого 64,016.7 сая төгрөг бүрэн бүрдсэн, үндсэн бус үйл ажиллагааны орлого 12,578.2 сая төгрөг бүрдүүлж 40.3 хувиар буюу 3,613.7 сая төгрөгөөр давж, нийт орлого 478,583.2 сая төгрөг болж 22.3 сая төгрөгөөр тасарсан байна.

Тайлант онд 486,842.0 сая төгрөг зарцуулахаас 405,905.7 сая төгрөгийг цахилгаан эрчим хүчний төлбөрт 72,698.9 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардалд 8,237.4 сая төгрөгийг үндсэн бус үйл ажиллагааны зардалд зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 2.0 хувиар буюу 8,280.6 сая төгрөгөөр хэмнэж 478,561.4 сая төгрөг зарцуулсан байна. Үүнээс 394,070.7 сая төгрөгийг цахилгаан эрчим хүчний төлбөрт, 74,570.9 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардалд 9,919.8 сая төгрөгийг үндсэн бус үйл ажиллагааны зардалд тус тус зарцуулсан байна.

Тайлангийн хугацаанд үндсэн үйл ажиллагааны зардалд 72,698.9 сая төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 74,570.9 сая төгрөгийг зарцуулж, үндсэн үйл ажиллагааны зардлыг 1,872.0 сая төгрөгөөр хэтрүүлсэн. Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардлыг 1.01 төгрөгөөр төсөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр мөн 0.99 төгрөгт хүрч ашгийн төлөвлөгөөг 8,258.3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Компани 2019 онд үндсэн бус үйл ажиллагааны зардал 8,237.4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөнөөс 9,919.8 сая төгрөг зарцуулж, 1,628.4 сая төгрөг буюу 20 хувь төлөвлөгөөнөөс хэтрэлттэй байна. Энэхүү хэтрэлт нь Үндсэн бус үйл ажиллагааны 8,964.4 сая.төгрөгийн орлого төлөвлөснөөс 12,578.2 сая төгрөгийн орлого олж 3,613.7 сая.төгрөгөөр буюу 40.3 хувиар давуулан биелүүлсэн бөгөөд үүнийг нэгж орлогод ногдуулан тооцвол төсөвлөснөөр 91 мөнгө байх бөгөөд гүйцэтгэлээр 78 мөнгө болж, үндсэн бус үйл ажиллагааны орлогын нэг төгрөг тутам гарах зардлыг 13 мөнгөөр хэмнэсэн байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 12 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 14 эрсдэл тодорхойлж нийт 22 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2,697.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 433.3 сая төгрөгийн зөрчилд акт, 377.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 1,887.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 8 зөвлөмж өгөв.

- Бэлтгэн нийлүүлэгчээс авах авлага дансанд 7 харилцагчийн 310.2 сая төгрөгийг шүүх хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэхээр хандсан боловч нотлох баримтын бүрдэлт хангалтгүй тул эцэслэн шийдвэрлэгдээгүй, 2 харилцагчийн 123.2 сая төгрөгийн авлага нь ажил үйлчилгээний чанарын шаардлага хангаагүй, нийт 433.3 сая төгрөгийн авлагыг он дамжин бүртгэж, үргүй зардал гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хууль, 6.4-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Компанийн тухай хуулийн 64.4.3-т "Компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах" гэсэн заалтад нийцэхгүй, бодитой оршин байх ба тохиолдсон байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Акт тогтоох

- "УБЦТС" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал асан нь Налайх ХҮТ-ийн салбарыг оффистой болгоход зориулж 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр иргэн Бадарай овогтой Баярсайханаас Налайх дүүргийн 01 дүгээр хороо, Уурхайчдын гудамж 20 тоот хаягт байрлалтай 357 м2 талбай бүхий объектыг, 182 м2 газрын хамт 200.0 сая төгрөгөөр худалдан авахаар 320/2012 тоот гэрээг байгуулж, 200.0 сая төгрөгийг шилжүүлсэн ба нэмж 159.0 сая төгрөгийн их засвар хийсэн байна. Уг объектыг зориулалтын дагуу ашиглаж, нягтлан бодох бүртгэлийн Үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн хэдийч барилгын үл хөдлөх хөрөнгийн эрхийн гэрчилгээгүй эзэмшигч нь тодорхойгүй нь бодитой оршин байх ба тохиолдсон байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

- Баруун түгээх төвийн няраваас авах /бараа материалын дутагдал/ 19.3 сая төгрөг, өгөх 1.7 сая төгрөгийн өглөг нийт 17.6 сая төгрөгийн авлагыг барагдуулах Гүйцэтгэх захирлын 2017 оны 8 дугаар сарын 10-ний өдрийн 8/394 тоот тушаал гарсан боловч тушаалыг хэрэгжүүлж ажлаагүй, өглөг, авлагыг цэвэр бодит дүнгээр бүртгэж тайлагнаагүй нь Компанийн тухай хуулийн 64.4.3-т "Компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах" гэсэн заалтад нийцэхгүй, бодитой оршин байх ба тохиолдсон байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Залруулагдаагүй 1,887.9 сая төгрөгийн алдаа зөрчилд 8 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 88 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 4 дүгээр сарын 09-ний 57 дугаар тушаал, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн агаар орчны бохирдлыг бууруулах ажлыг хэрэгжүүлэхийг “УБЦТС” ТӨХК-д үүрэг болгохдоо Улсын хөрөнгө оруулалтаар хийгдэх энэхүү ажлын хөрөнгийн эх үүсвэрийг Эрчим хүчний яам болон эрх бүхий дээд байгууллага нь Төрийн өмчит банкны зээлээр шийдвэрлэлгүй арилжааны банкны зээлээр санхүүжүүлэх шийдвэр гаргаснаар анх 17,387.5 сая төгрөгийн зээл авч, 1,482.0 сая төгрөгийн зээлийн хүүг нэмж зээлэн нийт 18,869.2 сая төгрөгийн зээл авсан байна. Нэмж авсан 1,482.0 сая төгрөгийн зээлд ногдох 120.3 сая төгрөгийн зээлийн хүү, нийт 18,989.8 сая төгрөгөөр дээрх ажлыг санхүүжүүлсэн байна.

Тус ажлын хөрөнгийн эх үүсвэрийг Эрчим хүчний яамны 2019 оны төсөвт баталснаар арилжааны банкаас авсан зээл, зээлийн хүүг төлж барагдуулсан хэдий ч Засгийн газар болон Эрчим хүчний яам тогтоол, шийдвэртээ дээрх ажлын хөрөнгийн эх үүсвэрийг Төрийн өмчит банкны зээлээр шийдвэрлээгүйгээс улсын төсвөөс **1,602.3** сая төгрөгийн зээлийн хүүгийн алдагдал буюу үргүй зардал гарсан тул хойшид эрх бүхий дээд байгууллага анхаарал хандуулах шаардлагатай байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 288 дугаар тогтоолын хавсралтад 3,124.8 сая төгрөгөөр тус компанийн тарифыг баталсан байна. Гэвч “Диспетчерийн үндэсний төв” ХХК-иас гаргасан хүсэлтийг үндэслэн ЭХЗ нь 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 449 дүгээр тогтоолоор тус компанийн тарифыг 1,544.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 4,669.4 сая төгрөгөөр баталсан байна. “Диспетчерийн үндэсний төв” ХХК-ийн зориулалт нь тодорхойгүйгээр татан авсан 1,544.6 сая төгрөгийг “УБЦТС” ТӨХК нь “диспетчерийн зохицуулалтын үйлчилгээний өртөг зардал” дансанд бүртгэж тайлагнасан байна. Энэхүү асуудалд эрх бүхий дээд байгууллага анхаарал хандуулах шаардлагатай байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу шилэн дансны цахим хуудаст мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn/ цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 2019 оны зорилтот түвшний хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн зорилтот түвшний төсөл, тухайн жилийн зорилтот түвшинд орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг тоо мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийн биелэлт 80 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны санхүү байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан, тодруулгад аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй дүгнэлт”

Залруулагдаагүй 1,887.9 сая төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон 4,792.0 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, НББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дэх заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Авлагын данстай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт

Засгийн Газрын 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 88 дугаар тогтоолын дагуу Эрчим хүчний яамны санхүүжилтээр Нийслэлийн агаар, орчны бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын 20602 айл өрхийг цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэх 24 багц ажлын гүйцэтгэлээс 22 багц ажлын гэрээг дүгнэсэн боловч, 2 компанийн гэрээг дүгнээгүй 5 харилцагчид өгөх нийт 532.3 сая төгрөгийн өглөг, авлага үүсгэж аккруэл сууриар бүртгэж, тайлагнаагүй, Эрчим хүчний яамтай харилцагчийн гүйцэтгэл тус бүрээр тооцоо нийлдэггүй зэрэг нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн алдаа байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д *"Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө"*, 20.2.5-д *"Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээ гаргахаас өмнө хянан баталгаажуулах"*, 20.2.6-д *"Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллогыг хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах"* гэсэн заалтад нийцэхгүй байна.

Шатахууны бодит үлдэгдлийг тулган шалгахад 2019 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс 31-ний өдрийн хооронд зарлагдсан буюу ажилтан /хэрэглэгч/-ны шатахууны картанд байршуулсан 21.3 сая төгрөгийн шатахууныг нягтлан бодох бүртгэлд авлагаар бүртгээгүй, шатахууны үлдэгдлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв гаргах үндэслэл болно"* гэсэн заалтад нийцэхгүй байна.

3.1.2. Эрсдэл

Санхүүгийн тайлангийн үлдэгдэл буруу илэрхийлэгдэх, ашиг, алдагдал бодит бусаар тайлагнагдаж хувьцаа эзэмшигчдэд буруу мэдээлэл өгөх эрсдэлтэй байна.

3.1.3. Өгсөн зөвлөмж

Бүртгэл хөтлөлтийг хуулийн дагуу аккруэл сууриар бүртгэж, авлага, өглөгийн үлдэгдэл тооцоог баталгаажуулж байх.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитын зөвлөмжийг хүлээн авч анхаарч ажиллах болно.

3.2. Анхан шатны нотлох баримтын бүрдэлтийн талаар

3.2.1. Илрүүлэлт

Авлагын дансанд бүртгэлтэй 9 харилцагчийн нийт 33.0 сая төгрөгийн үлдэгдлийг зардлаар тайлагнахдаа анхан шатны нотлох баримтын бүрдэл дутуу байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т *"Анхан шатны баримт нь НББ хөтлөх, санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв гаргах үндэслэл болно"* гэсэн заалтад нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал алдагдах, хөрөнгө шамшигдах, залилан үүсэх.

3.2.3. Өгсөн зөвлөмж

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитын зөвлөмжийг хүлээн авч анхаарч ажиллах болно.

3.3. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн алдаа

3.3.1. Илрүүлэлт

"УБЦТС" ТӨХК нь SAMWON MILLENNIA CO LTD-ийн санхүүжилтээр Налайх дүүрэгт байрлах нар салхины хосолмол эх үүсвэр бүхий батарейн байгууламжтай цахилгаан станцыг 10кв-ын шугам, 10/0.4 кв-ын дэд станц, реклозерын пунктын хамтаар "УБЦТС" ТӨХК-ийн түгээх сүлжээнд холбох ажлыг гүйцэтгүүлэхээр 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 2019/371 тоот ажил үйлчилгээний 121.0 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг байгуулж, төлбөрийг бүрэн хүлээн авсан байна. Энэхүү ажлын төлбөрийг орлогоор тайлагнаагүй, өглөгөөр бүртгэж тайлант жилийн орлогыг дутуу, үр дүнг буруу илэрхийлсэн байна. Эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга батламж, мэдэгдлийг хангахгүй байна.

"Ирвэст шүтээн" ХХК-тай байгуулсан 38.5 сая төгрөгийн ажил үйлчилгээний гэрээг 2019 оны 12 дугаар сарын 12-нд дүгнэсэн боловч өглөг, зардлаар аккруэль сууриар бүртгээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д *"Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэль сууриар хөтөлнө"* заалтад нийцэхгүй байна.

3.3.2. Эрсдэл

Үр дүнг бууруулж, санхүүгийн тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд буруу ташаа мэдээлэл хүрэх,

3.3.3. Өгсөн зөвлөмж

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, тооцооллыг хууль, журамд нийцүүлэн засаж, ажиллах талаар зөвлөмж өгөв.

3.3.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн алдаа зөрчлийг засаж ажиллах болно.

3.4. Бараа материалын үлдэгдэл, насжилт, тооллогын бүртгэл тайлангийн талаар

3.4.1. Илрүүлэлт

Бараа материал данснаас түүвэрт хамрагдсан 2006 оноос хойш одоог хүртэл огт ашиглагддаггүй, эргэлтгүй 967.5 сая төгрөгийн үхмэл шинжтэй үндсэн сэлбэг хэрэгсэл бүртгэлтэй байна. Худалдан авалтын тоо хэмжээг алба хэлтсүүд ашиглагдах хэмжээ, загвар, маркыг үнэн, зөв бодиттой гаргаж, төлөвлөн хянадаггүйгээс жил бүр үр ашиггүй, үргүй зардал гаргаж байна.

Бараа материалын жилийн эцсийн тооллогын тайланг хянан шалгахад дараах зөрчил ажиглагдаж байна. Үүнд жилийн эцсийн тооллогын үр дүнг 12 сарын 31-ний үлдэгдлээр тохируулдаггүй, тооллогын илтгэх хуудас болон тайланг бараа материалын ангилал тус бүрээр дэлгэрэнгүй бодитой бичдэггүй, тооллогын хуудсыг батлагдсан маягтын дагуу бэлтгэдэггүй, үнийн дүнгүй, санхүүгийн программаас үлдэгдлийг хуулж бичдэг, тооллого хийсэн протокол нь тооллогын шаардлагад нийцэхгүй гэх мэт зөрчилтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67.2-т *“Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт бүртгэлээр тавих хяналтыг ерөнхий нягтлан бодогч хариуцана”*, 70.2-т *“Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн тогтоосон хугацаанд явуулж, улирал жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнах”*, 72.4-д *“Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв чанартай явуулж дуусгах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т *“Анхан шатны баримт нь НББ хөтлөх, санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв гаргах үндэслэл болно”* гэсэн заалтад нийцэхгүй байна.

3.4.2. Эрсдэл

Эд, материал шамшигдах, үргүй зардал гарах, санхүүгийн тайлангийн үлдэгдэл буруу илэрхийлэгдэх.

3.4.3. Өгсөн зөвлөмж

Дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, батлагдсан маягтын дагуу үнэн зөв ангилан тайлагнаж, тооллогыг үнэн зөв бодиттой гүйцэтгэх, Бараа материалын худалдан авалтын төлөвлөгөөг боловсруулахдаа зах зээлийн судалгааг нарийвчлан хийж, алба хэлтсүүдээс өгсөн тоо мэдээлэлийг албажуулан тулгах, төлөвлөж байх зөвлөмж өгөв.

3.4.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

3.5. Гэрээний үүргийн биелэлтийн талаар

3.5.1. Илрүүлэлт

“Женерал энерго строй” ХХК-тай 2018 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр *“6-10 кв-ын хуваарилах самбар”*-ыг 319.0 сая төгрөгөөр худалдан авахаар 2018/332 тоот гэрээг байгуулсан. Энэхүү гэрээний 4 дүгээр заалтад *“барааг 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор нийлүүлж, хүлээлгэн өгөх”-нөөр* гэрээний төлбөрийг бүрэн шилжүүлэхээр гэрээлсэн боловч өнөөдрийг хүртэл 144.0 сая төгрөгийн барааг бүрэн хүлээн аваагүй, гэрээ дүгнээгүй, гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй, шаардлага хангахгүй бэлтгэн нийлүүлэгч сонгосон, худалдан авалтыг сонгох шалгуур үзүүлэлт хангалтгүй байгаа нь ажиглагдаж байна.

3.5.2. Эрсдэл

Үргүй зардал гарах эрсдэлтэй.

3.5.3. Өгсөн зөвлөмж

Гэрээ эрх зүйн мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд гэрээний хэрэгжилтэд бүрэн хяналт тавьж, мэдээллийн сан бүрдүүлж, хууль тогтоомжийн хүрээнд хөрөнгө захиран зарцуулах, компанийн эрх ашигт нийцсэн оновчтой шийдвэр гаргаж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах зөвлөмж өгөв.

3.5.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

3.6. Зардлын бүртгэлийн талаар

3.6.1. Илрүүлэлт

Улаанбаатар-Дархан чиглэлийн автозамын 0-73.1 км, 73.1-175 км хэсгийн өргөтгөлийн трасст орсон цахилгаан шугам сүлжээний өөрчлөлт болон 0-4.6 км хэсгийн гэрэлтүүлгийн цахилгаан хангамжийн барилга угсралтын ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн бөгөөд туслан гүйцэтгэгч компаниудын гэрээг бүрэн дүгнээгүй байхад цалин, механизмын орлого, зардал 30.3 сая төгрөгийг тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь иж бүрэн байх, үнэн зөв байх, тасалбар болголт зэрэг баталамж мэдэгдлийг хангахгүй байна.

3.6.2. Эрсдэл

Тайлант хугацааны ашиг, алдагдал буруу илэрхийлэгдэх

3.6.3. Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтад үндэслэн нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтлөх.

3.6.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

3.7. Нягтлан бодох бүртгэлийн программын талаар

3.7.1. Илрүүлэлт

Компанид ашиглагдаж буй санхүүгийн программд дараах дутагдал ажиглагдлаа. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн Даймонд-05 программ болон ХХХМС2-ийн Индикатор программд тоолуур хэмжих хэрэгслийн тоо ширхэг зөрүүтэй бүртгэгдэж байна. Тухайлбал: ХУД-ХҮТ-266 ширхэг, СХД-ХҮТ-, БГД-ХҮТ-, БЗД-ХҮТ- нийт 862 ширхэгээр зөрүүтэй байна.
- Гүйлгээний жагсаалтад харилцагчийн нэр гардаггүй,
- Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл өссөн дүнгээр гардаггүй, хуримтлагдсан элэгдэл болон сарын элэгдлийн дүн давхардаж гардаг энэ нь санхүүгийн тайлангийн үзүүлэлт, үлдэгдэлд нөлөөлдөггүй хэдий ч хөндлөнгийн шалгалт хийхэд ажиллагаа ихтэй байна.
- Төлөвлөлт, хангамжийн программын тоон мэдээлэл санхүүгийн программтай холбогддоггүйгээс компьютерын эксел программд давхар тооцоолол хийж, санхүүгийн программ мэдээллийг шивж оруулж байна.

3.7.2. Эрсдэл

Компанийн санхүү болон үйл ажиллагааны мэдээлэл алдагдах эрсдэлтэй байна.

3.7.3. Өгсөн зөвлөмж

Компанийн үйл ажиллагааг бүхэлд нь хамарсан программ хангамжийг судалж, шаардлага хангасан санхүүгийн программыг удирдлагаар шийдвэрлүүлэх.

3.7.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

3.8. Салбаруудын үйл ажиллагааны тооцоо нийлсэн актын талаар

3.8.1. Илрүүлэлт

Салбар нэгжүүдийн үйл ажиллагааны бус орлого зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийг, компанийн Төлөвлөлт эдийн заргийн хэлтсийн эдийн засагчтай тооцоо нийлж, журмын дагуу төвлөрүүлдэг 30%-ийг тооцсон, салбаруудын тооцоо нийлсэн актыг түүвэрлэн салбаруудын гүйлгээ балансын орлого, зардлын дүнтэй тулган шалгахад зарим салбарын цалин, нийгмийн даатгал, шатахууны зардал, харилцах дансны үлдэгдэл зөрүүтэй байгаа нь ажиглагдлаа.

3.8.3. Өгсөн зөвлөмж

Салбар нэгжүүд тооцоо нийлсэн актыг зарлага тус бүрээр зөрүүгүй тулгаж, актыг үйлдэж байх зөвлөмж өгөв.

3.8.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

3.9. Төрийн бодлогын чанартай хийгдэж байгаа ажлын талаар

3.9.1. Илрүүлэлт

Аудитын тайлангийн 2.11-д “Анхаарал татахуйц бусад чухал асуудалд” дурдсан Хөрөнгө оруулалтын шинж чанартай хийгдэж байгаа ажил, Монгол улсын Засгийн газрын тогтоол, Эрчим хүчний сайдын тушаалаар гүйцэтгэж буй ажилуудын хөрөнгийн эх үүсвэрийг банкны зээлээр санхүүжүүлж байгаа нь улсын төсөв зээлийн хүүгийн алдагдалд орох, үргүй зардал гаргах эрсдэлтэй байна.

3.9.2. Эрсдэл:

Улсын төсөвт үргүй зардал гарах, санхүүгийн тайлан, үр дүн буруу илэрхийлэгдэх

3.9.3 Өгсөн зөвлөмж:

Энэхүү асуудлыг эрх бүхий дээд байгууллага /ЭХЯ, ЭХЗХ /-ын удирдлагад танилцуулж, төрийн тогтоол, шийдвэр, бодлого, журмыг НББОУС /СТОУС-д нийцүүлэх талаар анхаарал хандуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	1,879,394,265.48	2,116,135,099.44
1.1.2	Дансны авлага	24,719,680,020.94	30,855,348,120.85
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	475,952,772.64	590,198,387.95
1.1.4	Бусад авлага	5,026,543,251.14	4,458,904,779.67
1.1.5	Бараа материал	8,915,700,404.81	9,540,649,924.74
1.1.6	Урьдчилж төлсөн зардал тооцоо	167,836,309.25	45,613,675.40
1.1.7	Эргэлтийн хөрөнгийн дүн	41,185,107,024.26	47,606,849,988.05
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	218,005,813,272.90	224,256,982,055.68
1.2.2	Биет бус хөрөнгө	848,027,724.50	737,938,154.81
1.2.3	Бусад эргэлтийн бус хөрөнгө	17,682,980,980.66	7,441,050,812.81
1.2.4	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	236,536,821,978.06	232,435,971,023.30
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	277,721,929,002.32	280,042,821,011.35
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	16,597,318,544.27	20,148,631,146.44
2.1.1.2	Цалингийн өглөг	3,353,892,047.62	2,701,027,292.43
2.1.1.3	Татварын өр	141,470,575.55	298,605,112.51
2.1.1.4	НДШ-ийн өглөг	106,956,514.66	8,692,175.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	13,972,026,882.94	-
2.1.1.6	Урьдчилж орсон орлого	1,300,769,732.07	1,233,099,012.54
2.1.1.8	Бусад богино хугацаат өр төлбөр	4,090,132,036.99	9,519,371,499.76
2.1.1.9	Богино хугацаат өр төлбөрийн дүн	39,562,566,334.10	33,909,426,238.68
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	35,580,206,764.35	33,225,818,757.08
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	2,729,745,174.97	3,076,459,610.30
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	17,054,323,641.73	17,249,863,794.74
2.1.2.20	Урт хугацаат өр төлбөрийн дүн	55,364,275,581.05	53,552,142,162.12
2.2	Өр төлбөрийн нийт дүн	94,926,841,915.15	87,461,568,400.80
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн өмч	80,760,025,198.32	118,530,858,480.10
2.3.2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	51,319,385,887.70	48,677,809,806.83
2.3.3	Эздийн өмчийн бусад хэсэг	44,371,066,418.61	18,254,874,358.07
2.3.4	Хуримтлагдсан ашиг	6,344,609,582.54	7,117,709,965.55
2.3.5	Эздийн өмчийн дүн	182,795,087,087.17	192,581,252,610.55
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	277,721,929,002.32	280,042,821,011.35

4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

СТ-2А

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	412,752,286,311.54	466,005,002,899.97
1.1	ЦЭХ борлуулалт	352,311,909,111.54	401,988,265,365.42
1.2	Түгээх үйлчилгээний орлого	60,440,377,200.00	64,016,737,534.55
2	Борлуулалтын өртөг	378,686,128,781.12	432,192,225,903.76
2.1	ХАЦЭХ	344,288,588,411.19	394,070,679,437.06
2.2	Түгээх үйл ажиллагааны зардал	34,397,540,369.93	38,121,546,466.70
3	Нийт ашиг (алдагдал)	34,066,157,530.42	33,812,776,996.21
4	Түрээсийн орлого	50,841,036.36	25,899,290.92
5	Хүүгийн орлого	147,521,794.83	56,956,409.49
6	Бусад орлого	8,240,724,206.58	12,495,262,889.56
7	Борлуулалт, маркетингийн зардал	25,109,786,815.73	25,419,643,882.35
8	Ерөнхий ба удирдлагын зардал	11,293,655,576.58	10,902,490,198.18
9	Санхүүгийн зардал	133,636,592.51	127,244,827.02
10	Бусад зардал	5,449,134,366.66	9,919,795,163.81
11	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	91,710.85	32,209.38
12	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	519,122,927.56	21,753,724.20
13	Орлогын татварын зардал	362,913,163.56	641,099,231.61
14	Татварын дараах ашиг (алдагдал)	156,209,764.00	(619,345,507.41)
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	156,209,764.00	(619,345,507.41)
16	Орлогын нийт дүн	156,209,764.00	(619,345,507.41)

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-3А

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/төгрөг/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	<i>Мөнгөн орлогын дүн</i>	609,659,742,135.90	539,409,600,941.71
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	354,354,336,877.13	410,234,096,538.04
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	426,967,958.00	396,722,348.30
1.1.6	Бусад мөнгөн орлого	254,878,437,300.77	128,778,782,055.37
1.2	<i>Мөнгөн зарлагын дүн</i>	(604,103,778,403.75)	(523,664,258,683.82)
1.2.1	Ажиллагчдад төлсөн	(32,162,929,916.94)	(34,011,047,828.26)
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(10,185,881,303.51)	(10,494,657,054.82)
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	(11,565,767,411.03)	(13,207,592,256.32)
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	(582,505,502.90)	(449,153,737.47)
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(1,869,434,121.33)	(1,741,169,399.00)
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	(1,017,597,576.78)	(1,393,347,429.27)
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	(9,609,670,536.34)	(9,632,513,875.70)
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	(240,000.00)	(57,690,162.00)
1.2.9	Бусад мөнгөн зарлага	(537,109,752,034.92)	(452,677,086,940.98)
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,555,963,732.15	15,745,342,257.89
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
2.1	<i>Мөнгөн орлогын дүн</i>	147,521,794.83	56,956,409.49
2.1.	Хүлээн авсан хүүний орлого	147,521,794.83	56,956,409.49
2.2	<i>Мөнгөн зарлагын дүн</i>	(20,369,851,219.08)	(17,705,036,749.84)
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(20,369,851,219.08)	(17,705,036,749.84)
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(20,222,329,424.25)	(17,648,080,340.35)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		-
3.1	<i>Мөнгөн орлогын дүн</i>	13,972,128,259.21	4,491,571,858.38
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	13,972,026,882.94	4,491,529,073.28
3.1.2	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	101,376.27	42,785.10
3.2	<i>Мөнгөн зарлагын дүн</i>	(2,352,092,031.66)	(2,352,092,941.96)
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	(2,352,082,366.24)	(2,352,082,366.24)
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	(9,665.42)	(10,575.72)
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	11,620,036,227.55	2,139,478,916.42
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(3,046,329,464.55)	236,740,833.96
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,925,723,730.03	1,879,394,265.48
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,879,394,265.48	2,116,135,099.44

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

СТ-4А

/төгрөг/

Д/д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	80,764,538,429.43	50,416,130,722.15	20,981,223,410.32	4,050,317,695.33	156,212,210,257.23
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(4,210,507,159.85)	(4,210,507,159.85)
3	Залруулсан үлдэгдэл	80,764,538,429.43	49,883,227,880.56	38,961,571,729.39	6,361,557,145.93	175,970,895,185.31
5	Өмчид гаргасан өөрчлөлт	(4,513,231.11)	(252,566,945.08)	5,409,494,689.22	170,702,132.61	5,323,116,645.64
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	(343,859,460.00)	(343,859,460.00)
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	156,209,764.00	156,209,764.00
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	1,688,724,952.22	-	-	1,688,724,952.22
9	2018 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	80,760,025,198.32	51,319,385,887.70	44,371,066,418.61	6,344,609,582.54	182,795,087,087.17
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
11	Залруулсан үлдэгдэл	80,760,025,198.32	51,319,385,887.70	44,371,066,418.61	6,344,609,582.54	182,795,087,087.17
12	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
13	Өмчид гаргасан өөрчлөлт	(133,116,408.89)	-	9,668,381,130.12	893,677,832.04	10,428,942,553.27
14	Зарласан ногдол ашиг	-	-	-	(23,431,522.46)	(23,431,522.46)
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(522,199,580.87)	(37,903,949,690.67)	(619,345,507.41)	(39,045,494,778.95)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	37,903,949,690.67	(2,119,376,500.00)	2,119,376,500.00	522,199,580.84	38,426,149,271.51
17	2019 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	118,530,858,480.10	48,677,809,806.83	18,254,874,358.06	7,117,709,965.55	192,581,252,610.54

4.5 Аудит хийгдсэн зорилтот түвшингийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

/сая төгрөг/

№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	2018 оны гүйцэтгэл	Өссөн дүн		Өөрчлөлт
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө/ гүйцэтгэл
А. Санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд							
1	Нийт орлого		сая.төг	421,191.5	478,605.4	478,583.2	(22.3)
	Үүнээс: Борлуулалтын орлого	Бичилт	сая.төг	352,311.9	405,624.3	401,988.3	(3,636.0)
		Цуглуулалт	сая.төг	349,236.5	405,624.3	397,048.4	(8,575.9)
	Борлуулалтын орлого цуглуулалтын хувь		%	99.1%	100.0%	98.8%	-1.2
	Түгээх үйлчилгээний орлого		сая.төг	60,440.4	64,016.7	64,016.7	(0.0)
Үйл ажиллагааны бус орлого		сая.төг	8,439.2	8,964.4	12,578.2	3,613.7	
2	Нийт зардал		сая.төг	420,672.3	486,842.0	478,561.4	(8,280.6)
	Үүнээс: Үйл ажиллагааны зардал		сая.төг	415,223.2	478,604.6	468,641.6	(9,963.0)
	Үйл ажиллагааны зардал		сая.төг	70,934.6	72,698.9	74,570.9	1,872.0
	ХАЦ-ын өртөг		сая.төг	344,288.6	405,905.7	394,070.7	(11,835.0)
Үйл ажиллагааны бус зардал		сая.төг	5,449.1	8,237.4	9,919.8	1,682.4	
3	Үйл ажиллагааны ашиг, алдагдал		сая.төг	519.1	(8,236.6)	21.8	8,258.3
Орлогын татварын зардал			362.9		641.1	641.1	
4	Татварын дараахи ашиг, алдагдал		сая.төг	156.2	(8,236.6)	(619.3)	7,617.2
5	<i>Нийт авлага</i>		сая.төг	29,222.2	28,843.4	35,904.5	7,061.1
	Үүнээс:	ЦЭХ-ний	сая.төг	23,719.7	24,743.4	30,855.3	6,111.9
		Бусад	сая.төг	5,502.5	4,100.0	5,049.1	949.1
6	<i>Нийт өглөг</i>		сая.төг	94,926.8	79,963.4	87,461.6	7,498.2
	Үүнээс:	УХӨТ	сая.төг	55,364.3	54,886.3	53,552.1	(1,334.2)
		БХӨТ	сая.төг	39,562.6	25,077.1	33,909.4	8,832.3
7	Эргэлтийн хөрөнгө		сая.төг	40,185.1	-	47,606.9	
8	<i>Эргэлтийн бус хөрөнгө /үндсэн хөрөнгө/</i>		<i>сая.төг</i>	<i>236,536.8</i>	<i>-</i>	<i>232,436.0</i>	<i>-</i>
	Үүнээс: Үйлдвэрлэлийн		сая.төг	218,005.8		224,257.0	
	Ерөнхий хэрэглээний		сая.төг	-		-	
	Бусад		сая.төг	18,531.0		8,179.0	
9	Нийт ажиллагсад		тоо	1,919	1,919	1,920	1.0
10	Цалингийн сан		сая.төг	35,049.8	35,386.5	35,373.0	(13.6)
11	Дундаж цалин		төгрөг	1,352,665	1,394,890	1,393,784	(1,105.7)
	Үүнээс:	Удирдлага	төгрөг	3,140,753	2,769,501	2,965,049	195,548
		ИТА	төгрөг	1,538,668	1,564,212	1,561,484	(2,728.4)

“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит

№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	2018 оны гүйцэтгэл	Өссөн дүн		Өөрчлөлт
					Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө/ гүйцэтгэл
		Ажилчид	төгрөг	1,229,342	1,284,163	1,204,325	(79,838.7)
	Б.Техник эдийн засгийн үзүүлэлт						
12	Түгээлтэнд авсан цахилгаан		мян.кВтц	2,934,617.4	3,160,015.2	3,067,914.6	(92,100.6)
13	Түгээлтэнд авсан цахилгааны дундаж тариф		төг/кВтц	117.32	128.45	128.45	(0.0)
14	Түгээлтэнд авсан цахилгааны нийт өртөг		сая.төг	344,288.6	405,905.7	394,070.7	(11,835.0)
15	Цахилгаан түгээлтийн алдагдал	Биет	мян.кВтц	445,808.6	485,791.2	458,153.80	(27,637.4)
		Хувь	%	15.19%	15.37%	14.93%	(0.0)
	Үүнээс: техникийн	Биетээр	мян.кВтц	263,157.6	273,847.9	260,516.2	(13,331.7)
		Хувиар	%	8.97%	8.67%	8.49%	(0.0)
	арилжааны	Биетээр	мян.кВтц	182,650.9	211,943.3	197,637.6	(14,305.6)
		Хувиар	хувь	6.22%	6.7%	6.44%	(0.0)
16	Борлуулсан цахилгаан		мян.кВтц	2,488,808.8	2,674,224.1	2,609,760.8	(64,463.3)
17	Борлуулсан цахилгааны дундаж тариф		төг/кВтц	140.68	151.68	153.02	1.3
	Нийт хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ		сая.төг	15,067.6	14,753.9	10,933.6	(3,820.3)
18	Их засвар хийсэн тоноглол		тоо	-	23.0	23.0	-
	Үүнээс:	Үндсэн	тоо	-	15.0	15.0	-
		Туслах	тоо	-	8.0	8.0	-
19	Их засварт зарцуулсан хөрөнгө		сая.төг	2,474.9	3,939.7	2,561.8	(1,377.8)
	Үүнээс:	Үндсэн	сая.төг	-	2,941.9	1,932.6	-
		Туслах	сая.төг	-	465.9	465.3	-
		Бусад	сая.төг	-	80.5	77.0	-
20	ТЗБАХ-нд зарцуулсан хөрөнгө		сая.төг	4,689.8	6,577.8	5,089.6	(1,488.2)
	Гүйцэтгэсэн ажил		тоо	-	62.0	61.0	(1.0)
21	Хөрөнгө оруулалтанд зарцуулсан хөрөнгө		сая.төг	7,903.0	4,236.5	3,282.2	(954.3)

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2020/33/СТА-ТӨХК
Шалгагдсан байгууллагын нэр:		“Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК		сая төгрөг	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	<p>Засгийн Газрын 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 88 дугаар тогтоолын дагуу Эрчим хүчний яамны санхүүжилтээр Нийслэлийн агаар, орчны бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын 20602 айл өрхийг цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэх 24 багц ажлын гүйцэтгэлээс 22 багц ажлын гэрээг дүгнэсэн боловч, 2 компанийн гэрээг дүгнээгүй 5 харилцагчид өгөх нийт 532.3 сая төгрөгийн өглөг, авлага үүсгэж аккруэл сууриар бүртгэж, тайлагнаагүй, Эрчим хүчний яамтай харилцагчийн гүйцэтгэл тус бүрээр тооцоо нийлдэггүй зэрэг нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн алдаа гарсан байна.</p> <p>Шатахууны тайлангийн шатахууны бодит үлдэгдлийг тулган шалгахад 2019 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс 31-ний өдрийн хооронд зарлагдсан буюу ажилтан /хэрэглэгч/-ны шатахууны картанд байршуулсан 21.3 сая төгрөгийн шатахууныг нягтлан бодох бүртгэлд авлагаар бүртгээгүй, шатахууны үлдэгдлийг бодитоор тайлагнаагүй байна.</p>	532.3	Зөвлөмж өгөх	Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч	О. Ариунболд
	21.3	Ахлах нягтлан бодогч		Д.Төгсжаргалан	
2	<p>Авлагын дансанд бүртгэлтэй 9 харилцагчийн нийт 33.0 сая төгрөгийн үлдэгдлийг зардлаар тайлагнахдаа анхан шатны нотлох баримт бүрдэлт дутуу байна.</p>	33.0	Зөвлөмж өгөх	Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч	О. Ариунболд
				Ахлах нягтлан бодогч	Д.Төгсжаргалан

3	<p>"УБЦТС" ТӨХК-нь SAMWON MILLENNIA CO LTD-ийн санхүүжилтээр Налайх дүүрэгт байрлах нар салхины хосломол эх үүсвэр бүхий батарейн байгууламжтай цахилгаан станцыг 10кв-ын шугам, 10/0.4 кв-ын дэд станц, реклозерын пунктын хамтаар "УБЦТС" ТӨХК-ийн түгээх сүлжээнд холбох ажлыг гүйцэтгүүлэхээр 2019 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 2019/371 тоот ажил үйлчилгээний 121.0 сая төгрөгийн үнийн дүнтэй гэрээг байгуулж, төлбөрийг бүрэн хүлээн авсан байна. Энэхүү ажлын төлбөрийг орлогоор тайлагнаагүй өглөгөөр бүртгэж тайлант жилийн орлогыг дутуу, үр дүнг буруу илэрхийлсэн байна. Эрх ба үүрэг, толилуулга ба тодруулга батламж, мэдэгдлийг хангахгүй байна.</p> <p>"Ирвэст шүтээн" ХХК-тай байгуулсан 38.5 сая төгрөгийн гэрээт ажил үйлчилгээг 2019 оны 12 дугаар сарын 12-нд гэрээ дүгнэсэн боловч өглөг, зардлаар аккруэль сууриар бүртгээгүй</p>	121.0	Зөвлөмж өгөх	<p>Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч</p> <p>Ахлах нягтлан бодогч</p>	<p>О. Ариунболд</p> <p>Д.Төгсжаргалан</p>
4	<p>Бараа материал данснаас түүвэрт хамрагдсан 2006 оноос хойш одоог хүртэл огт ашиглагддаггүй, эргэлтгүй 967.5 сая төгрөгийн үхмэл шинжтэй үндсэн сэлбэг хэрэгсэл бүртгэлтэй байна. Худалдан авалтын тоо хэмжээг алба хэлтсүүд ашиглагдах хэмжээ, загвар, маркыг үнэн, зөв бодиттой гаргаж, төлөвлөн хянадаггүйгээс жил бүр үр ашиггүй, үргүй зардал гаргаж байна.</p> <p>Бараа материал жилийн эцсийн тооллогын тайланг хянан шалгахад дараах зөрчил ажиглагдаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Жилийн эцсийн тооллогын үр дүнг 12 сарын 31-ний үлдэгдлээр тохируулдаггүй, - Тооллогын илтгэх хуудас болон тайланг бараа материалын ангилал тус бүрээр дэлгэрэнгүй бодитой бичдэггүй, - Тооллогын хуудсыг батлагдсан маягтын дагуу бэлтгэдэггүй, үнийн дүнгүй, санхүүгийн программаас үлдэгдлийг хуулж бичдэг, - Тооллого хийсэн протокол нь тооллогын шаардлагад нийцэхгүй гэх мэт зөрчилтэй байна 	967.5	Зөвлөмж өгөх	<p>Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч</p> <p>Ахлах нягтлан бодогч</p>	<p>О. Ариунболд</p> <p>Д.Төгсжаргалан</p>
5	<p>"Женерал энерго строй" ХХК-тай 2018 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр "6-10 кв-ын хуваарилах самбар"-ыг 319.0 сая төгрөгөөр худалдан авахаар 2018/332 тоот гэрээг байгуулсан. Энэхүү гэрээний 4 дүгээр заалтад "барааг 2018 оны 10</p>	144.0	Зөвлөмж өгөх	Хангамж үйлчилгээний албаны дарга	Ш.Оюунчимэг

	дугаар сарын 01-ний өдрийн дотор нийлүүлж, хүлээлгэн өгөх”-өөр гэрээлсэн боловч өнөөдрийг хүртэл 144.0 сая төгрөгийн барааг бүрэн хүлээн аваагүй, гэрээ дүгнээгүй, гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй, шаардлага хангахгүй бэлтгэн нийлүүлэгч сонгосон, худалдан авалтыг сонгох шалгуур үзүүлэлт хангалтгүй байгаа нь ажиглагдаж байна.			Захиргаа хүний нөөцийн хэлтсийн ахлах мэргэжилтэн	Н.Төрболд
6	Улаанбаатар-Дархан чиглэлийн автозамын 0-73.1 км, 73.1-175 км хэсгийн өргөтгөлийн трасст орсон цахилгаан шугам сүлжээний өөрчлөлт болон 0-4.6 км хэсгийн гэрэлтүүлгийн цахилгаан хангамжийн барилга угсралтын ажлыг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн бөгөөд туслан гүйцэтгэгч компаниудын гэрээ бүрэн дүгнээгүй байхад цалин, механизмын орлого, зардал 30.3 сая төгрөгийг тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь иж бүрэн байх, үнэн зөв байх, тасалбар болголт зэрэг баталамж мэдэгдлийг хангахгүй байна.	30.3	Зөвлөмж өгөх	Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Ахлах нягтлан бодогч	О. Ариунболд Д.Төгсжаргалан
7	Компанид ашиглагдаж буй санхүүгийн программд дараах дутагдал ажиглагдлаа. Үүнд: - Нягтлан бодох бүртгэлийн Даймонд-05 программ болон ХХХМС2-ийн Индикатор программд тоолуур хэмжих хэрэгслийн тоо ширхэг зөрүүтэй бүртгэгдэж байна. Тухайлбал: ХУД-ХҮТ-266 ширхэг, СХД-ХҮТ-, БГД-ХҮТ-, БЗД-ХҮТ- нийт 862 ширхэгээр зөрүүтэй байна. - Гүйлгээний жагсаалтад харилцагчийн нэр гардаггүй, - Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл өссөн дүнгээр гардаггүй, хуримтлагдсан элэгдэл болон сарын элэгдлийн дүн давхардаж гардаг энэ нь санхүүгийн тайлангийн үзүүлэлт, үлдэгдэлд нөлөөлдөггүй хэдий ч хөндлөнгийн шалгалт хийхэд ажиллагаа ихтэй байна. Төлөвлөлт, хангамжийн программын тоон мэдээлэл санхүүгийн программтай холбогддоггүйгээс компьютерын эксел программд давхар тооцоолол хийж, санхүүгийн программ мэдээллийг шивж оруулж байна.		Зөвлөмж өгөх	Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Ахлах нягтлан бодогч	О. Ариунболд Д.Төгсжаргалан
8	Салбар нэгжүүдийн үйл ажиллагааны бус орлого зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийг, компанийн Төлөвлөлт эдийн заргийн хэлтсийн эдийн засагчтай тооцоо нийлж, журмын дагуу төвлөрүүлдэг 30%-ийг тооцсон, салбаруудын тооцоо нийлсэн актыг түүвэрлэн салбаруудын гүйлгээ		Зөвлөмж өгөх		

	балансын орлого, зардлын дүнтэй тулган шалгахад зарим салбарын цалин, нийгмийн даатгал, шатахууны зардал, харилцах дансны үлдэгдэл зөрүүтэй байгаа нь ажиглагдлаа.				
9	Баруун түгээх төвийн няраваас авах /бараа материалын дутагдал/ 19.3 сая төгрөг, өгөх 1.7 сая төгрөгийн өглөг нийт 17.6 сая төгрөгийн авлагыг барагдуулах Гүйцэтгэх захирлын 2017 оны 8 дугаар сарын 10-ний өдрийн 8/394 тоот тушаал гарсан боловч тушаалыг хэрэгжүүлж ажлаагүй, өглөг, авлагыг цэвэр бодит дүнгээр бүртгэж тайлагнаагүй байна.	17.6	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч	Д.Баярсайхан О. Ариунболд
10	"УБЦТС" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал асан нь Налайх ХҮТ-ийн салбарыг оффистой болгоход зориулж 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр иргэн Бадарай овогтой Баярсайханаас Налайх дүүргийн 01 дүгээр хороо, Уурхайчдын гудамж 20 тоот хаягт байрлалтай 357 м2 талбай бүхий объектыг, 182 м2 газрын хамт 200.0 сая төгрөгөөр худалдан авахаар 320/2012 тоот гэрээг байгуулж, 200.0 сая төгрөгийг шилжүүлсэн ба нэмж 159.0 сая төгрөгийн их засвар хийсэн байна. Уг объектыг зориулалтын дагуу ашиглаж, нягтлан бодох бүртгэлийн Үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн хэдийч барилгын үл хөдлөх хөрөнгийн эрхийн гэрчилгээгүй эзэмшигч нь тодорхойгүй байна.	359.0	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Ахлах нягтлан бодогч	Д.Баярсайхан О. Ариунболд Д.Төгсжаргалан
11	Бэлтгэн нийлүүлэгчээс авах авлага дансанд 7 харилцагчийн 310.2 сая төгрөгийг шүүх хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэхээр хандсан боловч нотлох баримтын бүрдэлт хангалтгүй тул эцэслэн шийдвэрлэгдээгүй, 2 харилцагчийн 123.2 сая төгрөгийн авлага нь ажил үйлчилгээний чанарын шаардлага хангаагүй, нийт 433.3 сая төгрөгийн авлагыг он дамжин бүртгэж, үргүй зардал гаргасан байна.	433.3	Акт	Гүйцэтгэх захирал Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Ахлах нягтлан бодогч	Д.Баярсайхан О. Ариунболд Д.Төгсжаргалан
12	Аудитын тайлангийн 2.11-д “Анхаарал татахуйц бусад чухал асуудалд” дурдсан Хөрөнгө оруулалтын шинж чанартай хийгдэж байгаа ажил, Монгол улсын Засгийн газрын тогтоол, Эрчим хүчний сайдын тушаалаар гүйцэтгэж буй ажилуудын хөрөнгийн эх үүсвэрийг банкны зээлээр санхүүжүүлж байгаа нь улсын төсөв зээлийн хүүгийн алдагдалд орох, үргүй зардал гаргах эрсдэлтэй байна.		Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Ахлах нягтлан бодогч	Д.Баярсайхан О. Ариунболд Д.Төгсжаргалан
Алдаа зөрчлийн нийт дүн		2,697.5			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2020 оны 03 дугаар сарын 18

№ 02/53

Улаанбаатар хот

САГ-2020/33/СТА-ТӨЧГ

Төлбөр буцаан төвлөрүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т заасан цаглабарт хугацааны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Бэлтгэн нийлүүлэгчээс авах авлага дансанд 7 харилцагчийн 310.2 сая төгрөгийг шүүх хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэхээр хандсан боловч нотлох баримтын бүрдэлт хангалтгүй тул эцэслэн шийдвэрлэгдээгүй, 2 харилцагчийн 123.2 сая төгрөгийн авлага нь ажил үйлчилгээний чанарын шаардлага хангаагүй, нийт 433.3 сая төгрөгийн авлагыг он дамжин бүртгэж, үргүй зардал гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хууль, 6.4-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Компанийн тухай хуулийн 64.4.3-т "Компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах ..., акт тавих ...", 2016 оны Монгол улсын ерөнхий аудиторын А/95 тоот тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 3.1-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хугацаа хэтэрсэн он дамжсан, ажил үйлчилгээний чанарын шаардлага хангаагүй 433.3 сая төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сангийн 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг "Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Баярсайхан, ерөнхий нягтлан бодогч О.Ариунболд нарт үүрэг болгосугай.

АКТЫГ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

[Signature]

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР

Г.ТҮВШИНЗАЯА

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН:

"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК-ИЙН
АУДИТЫН МЕНЕЖЕР *[Signature]* Б.ДЭЛГЭРМАА

АХЛАХ АУДИТОР *[Signature]*

Л.БОЛОРЦЭЦЭГ

ЗӨВШӨӨРСӨН:

УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

[Signature] Д.БАЯРСАЙХАН
ЕРӨНХИЙ НИЯГТЛАН БОДОГЧ
О.АРИУНБОЛД

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харцуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Kherev\Akt\2020\03175AG3.Docx

001090152



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2020 оны 03 дугаар сарын 18 № 02/124
СМН-2020/33/СТА-794Г

Улаанбаатар хот

┌ Албан шаардлага хүргүүлэх тухай ┐

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Баруун түгээх төвийн нярваас авах /бараа материалын дутагдал/ 19.3 сая төгрөг, өгөх 1.7 сая төгрөгийн өглөг нийт 17.6 сая төгрөгийн авлагыг барагдуулах Гүйцэтгэх захирлын 2017 оны 8 дугаар сарын 10-ний өдрийн 8/394 тоот тушаал гарсан боловч тушаалыг хэрэгжүүлж ажлаагүй, өглөг, авлагыг цэвэр бодит дүнгээр бүртгэж тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хууль, 6.4-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Компанийн тухай хуулийн 64.4.3-т "Компанийн эрх ашигт нийцүүлэн үндэслэлтэй шийдвэр гаргах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх"; 18-р зүйл 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12. "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1. "...дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гүйцэтгэх захирлын 2017 оны 8 дугаар сарын 10-ний өдрийн 8/394 тоот тушаал гарсан боловч тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй, өглөг, авлагыг цэвэр бодит дүнгээр бүртгэж тайлагнаагүй буруутай албан тушаалтанд хариуцлага тооцож, авлага барагдуулах талаар тодорхой ажил хэрэгжүүлэх, биелэлтийг 2020 оны 01 сараас хэтрэхгүй хугацаа өгч Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Баярсайхан, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч О.Ариунболд нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.Наранчимэг Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР *Г.Түвшинзаяа* Г.ТҮВШИНЗАЯА

ӨГСӨН:

ГРАНТ ТОРНТОН АУДИТ ТӨХК-ИЙН
АУДИТЫН МЕНЕЖЕР
Б.Дэлгэрмаа Б.ДЭЛГЭРМАА

АХЛАХ АУДИТОР *Л.Болорцэцэг* Л.БОЛОРЦЭЦЭГ

ЗӨВШӨӨРСӨН:

“УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.Баярсайхан Д.БАЯРСАЙХАН

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
О.Ариунболд О.АРИУНБОЛД

Акт, албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харцуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 18 № 02/125
СЭТ 2020/33/СТА-ТӨЧГ

Улаанбаатар хот

Албан шаардлага хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- “УБЦТС” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал асан нь Налайх ХҮТ-ийн салбарыг оффистой болгоход зориулж 2012 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр иргэн Бадарай овогтой Баярсайханаас Налайх дүүргийн 01 дүгээр хороо, Уурхайчдын гудамж 20 тоот хаягт байрлалтай 357 м2 талбай бүхий объектыг, 182 м2 газрын хамт 200.0 сая төгрөгөөр худалдан авахаар 320/2012 тоот гэрээг байгуулж, 200.0 сая төгрөгийг шилжүүлсэн ба нэмж 159.0 сая төгрөгийн их засвар хийсэн байна. Уг объектыг зориулалтын дагуу ашиглаж, нягтлан бодох бүртгэлийн Үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн хэдийч барилгын үл хөдлөх хөрөнгийн эрхийн гэрчилгээгүй эзэмшигч нь тодорхойгүй байна. Энэ нь эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 193 тоот тогтоолын 5. “Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх болон тухайн хөрөнгийг төрийн байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12. “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.-г “... дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Дээрх объектыг Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлэх, гэрчилгээтэй болох.
- Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Д.Баярсайхан, ерөнхий нягтлан бодогч О.Ариунболд нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР Г.ТҮВШИНЗАЯА

ӨГСӨН:

ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК-ИЙН
АУДИТЫН МЕНЕЖЕР
Б.ДЭЛГЭРМАА

АХЛАХ АУДИТОР:
Л. БОЛОРЦЭЦЭГ

ЗӨВШӨӨРСӨН:

“УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.БАЯРСАЙХАН

ЕРӨНХИЙ НИЯГТЛАН БОДОГЧ

О.АРИУНБОЛД

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлдэг” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, spaced evenly down the page.

